

**Нэг. Нийтлэг үндэслэл, зохион байгуулалт, арга зүй**

**2023.02.26**

**Улиастай**

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнд Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан тайланг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд орон нутагт холбогдолтой 4 бодлого 15 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган ажиллаж байна.

**Хоёр.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**


Хяналт шинжилгээний зорилго нь Засгийн газрын үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлж, ард иргэдэд төр, засгийн бодлого шийдвэр, үйл ажиллагааг сурталчилах, төрийн үйл ажиллагааг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй, хүргэж байгаа байдал, хэрэгжилт, хэрэгжилтийн явцыг тодорхойлон, үйл ажиллагааг эрчимжүүлэх үр дүнтэй хэрэгжүүлэхэд, үнэлгээний зорилго нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийг зорилт, суурь түвшин, хүрэх түвшинтэй харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, үүрэг болгосон зүйл заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллахад чиглэл болоход оршино.

**Гурав. Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүн**

## Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг

хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд орон нутагт холбогдолтой тусгагдсан 17 заалт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг бодлого, зорилт тус бүрээр авч үзвэл: Эдийн засгийн бодлогын хүрээнд 5 зорилтын 5 арга хэмжээ, Засаглалын бодлогын хүрээнд 1 зорилтын 3 арга хэмжээ, Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд 3 зорилтын 3 арга хэмжээ, Нийслэл болон бүс орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд 6 зорилтын 6 арга хэмжээг тус тус хяналтад авсан ба нэгдсэн үнэлгээгээр 80 хувийн хэрэгжилттэй байна.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцохдоо хөтөлбөрийн батлагдсан хугацаанаас эхэлж хийж хэрэгжүүлсэн ажлын явцаар тайлагнасан болно.



### Дөрөв. Үнэлгээний дүгнэлт

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 бодлого, 15 зорилтын 17 арга хэмжээг хяналтанд авч орон нутагт хэрэгжүүлэн ажиллалаа.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явцыг хэлэлцүүлж орон нутагт даалгасан заалтуудыг эрчимжүүлж ажиллахыг холбогдох хэлтэс, агентлагийн дарга нарт чиглэл өгч, холбогдох дээд шатны байгууллагатай уялдаа холбоотой ажиллахыг үүрэг болгосон.

2023 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 52,9 хувийг үр дүнтэй, 47.1 хувийг тодорхой үр дүнд хүрсэн арга хэмжээ байна.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүнтэй ажил болгохоор орон нутгийн бодлогын баримт бичиг, 2024 оны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж ажиллахаар төлөвлөсөн байна.

## ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС



**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО**

Бодлогын нэр	Зорилтын нэр	Нийт арга хэмжээний	Хэрэгжилтийн явц						Хугацаа болоогүй	Хэрэгжилтийн дүн
			Үүний дотор							
			100	90	70	50	30	0		
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	3.3.6. Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	1	1						100	
	3.3.9. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.	1	1						100	
	3.7.4. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууриныг тодорхойлж, агаарын тээвэр, авто зам, төмөр замын сүлжээнд холбоно.	1	1						100	
	3.7.9. Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан үе шаттай эхлүүлнэ.	1			1				50	



	3.7.12. Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	1			1					<b>70</b>
<b>Дүн</b>		<b>5</b>	<b>3</b>		<b>1</b>	<b>1</b>				<b>84</b>
<b>ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>	4.6.3. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.	3	1	1	1					<b>86.6</b>
<b>Дүн</b>		<b>39</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>1</b>					<b>86.6</b>
<b>ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>	5.1.4. Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	1				1				<b>50</b>
	5.1.8. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.	1		1						<b>90</b>
	5.1.11. "Хөх морь" төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги, Хэрлэн-Тоонот төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан төслийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ.	1		1						<b>90</b>
<b>Дүн</b>		<b>3</b>		<b>2</b>		<b>1</b>				<b>76.6</b>
<b>ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>	6.2.5. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.	1			1					<b>70</b>
	6.2.8. Инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.	1			1					<b>70</b>



	6.2.10. Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.	1	1							<b>100</b>
	6.2.12. Сум, орон нутагт ажиллахаар анх удаа очиж байгаа багш, эмч, төрийн албан хаагчдыг орон байраар түр хангах цогц арга хэмжээг төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлнэ.	1				1				<b>50</b>
	6.2.13. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	1			1					<b>70</b>
	6.2.14.. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.	1		1						<b>90</b>
	<b>Дүн</b>	<b>6</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>1</b>				<b>75</b>
<b>4 бодлого</b>	<b>15 зорилт</b>	<b>17</b>	<b>5</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>3</b>				<b>80.5</b>

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**